

Хотын эмнэлгийн салбарууд

1925-12-11-энд Засгийн газрын 44-р хурлаар Хотын захиргааг жинхэнэ болгож, дүрмийг улсын бага хурлын тэргүүлэгчдэд явуулан батлуулахаар тогтоожээ.

1925-12-11-энд Улсын 2 дугаар Их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна.

Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан бөгөөд хэлтсүүд нь Ерөнхий хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Ардын эрүүлийг сахих хэлтэс, Аж үйлдвэрийн хэлтэс /энэхүү хэлтэст санхүү, аж ахуй, тоо бүртгэх салбарууд хамаарагдаж байв/-тэй байхаар заажээ. Хэлтсүүд нь тухайн үеийн байдлаас өөрчлөгдөж байжээ.

Албан газар, цэрэг, үйлдвэрийн хэлтсүүдтэй болсон байна.

1925 онд хотын захиргаа нь 6 хэлтэс, 104 орон тоотой байв.

Улсын 2 дугаар их хурлын шийдвэр болон Засгийн газрын 22 дугаар хурлын 7-р зүйлийг үндэслэн

1926-9-3-нд Засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927-1- 1-гээс эхлэн хотын захиргааны газрыг Дотоод яамны харьяанаас өөрчилж тусгай эрхтэй биеэ даасан газар болгохоор заажээ.

БНМАУ-ын 2 дугаар их хурлын 9 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл, Засгийн газрын 22 дугаар тогтоолын 17 дугаар зүйлээр Засгийн газрын комиссын саналыг үндэслэн 1926 оны 9 дүгээр сарын 3-анд Ардын засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927 оны 1 дүгээр сарын 1-гээс эхлэн хотын захиргааг Дотоод яамны харьяанаас өөрчилж, тусгай эрхтэй, биеэ даасан газар болгохоор тогтоожээ.

1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан.

1931-2-26-анд Засгийн газрын эрхлэх товчооны 10-р хурлын 5-р зүйлээр орон нутгийн захиргааг шинэчлэн өөрчлөх хувьсгалт түр хороодыг түр хороо гэж нэрлэхээр тогтоожээ.

1931 оны 2 дугаар сард нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалт явуулах “ түр хороод” аймгуудад байгуулагдсан ба мөн 3 дугаар сард сумдад “түр захиргаа” байгуулсан. Мөн 3, 4 дүгээр сард хуучин аймгийн яам, хошуудын тамгын газрын татан буулгаж, шинэ байгуулагдсан сум, аймгийн ардын төлөөлөгчдийн 1 дүгээр их хурал хуралдаж, тариалан зэрэг 13 аймаг байгуулагджээ.

1931-3-29-энд Засгийн газрын эрхлэх товчооны 15-р хурлын 3 дугаар зүйлээр Засаг захиргааны газруудад тамга, тэмдэг гэж давхар олгохыг зогсоож ганц тамга олгох, дөрвөлжин маягийг өөрчлөн дугуй хэлбэртэй болгохоор тогтоожээ.

1931-9-7-онд Засгийн газрын 20-р тогтоолын 4-р зүйлээр Төв аймаг, хотын захиргааг нэгтгэх тухай асуудал боловсруулах комиссыг томилсон байна.

1931-9-21-энд УБХ-ын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч, нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, Цагдан сэргийлэх явдлын хэлтэс, Улсын хянан байцаах бүртгэлийг Эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1931 оны 9 дугаар сарын 21-энд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлаар, Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа, нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж, “Улаанбаатар” хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг мөн оны 10 дугаар сарын 1-энд хийхээр тогтоожээ.

1931 онд Төв аймаг, хотын захиргаанд явуулсан ажлын тухай илтгэх хуудсанд Улаанбаатар аймгийн захиргааг 1931 оны 10 дугаар сард шинэчлэн нэгтгэж байгуулсан /Хуучин Төв аймагтай/ 1931 оны 3 дугаар сараас хотуудыг өөрчилсөн байна.

1932-8-5 анд Сайд нарын Зөвлөлийн 7-р тогтоолын 11-р зүйлээр Улаанбаатар аймгийн захиргааны зохион байгуулалтыг - 3-5 хүнтэй тэргүүлэгчид - Малын ажил ба хадлан тариалангийн хэлтэс - Цэргийн хэлтэс - Санхүүгийн хэлтэс - Ардыг гэгээрүүлэх хэлтэс - Хотын аж ахуйн хэлтэс - Бичиг дансны ангитайгаар баталжээ.

1932-5-27-онд Сайд нарын Зөвлөлийн 9-р тогтоолын 3-р зүйлээр 1931 онд Төв аймаг ба Улаанбаатар хотын захиргааг нэгтгэсэн нь үр дүн өгөөгүй учир салгаж аймаг, хотын захиргаа тус тусад нь байгуулахаар тогтоожээ.

1932 онд Сайд нарын Зөвлөлөөс гаргасан тогтоол /хагас/-д дурдахдаа хүний урьд Сайд нарын Зөвлөлөөс Улаанбаатар хотын захиргааг аж ахуйн талаар биеэ даасан газар болгож ялган байгуулах тухай гаргасан тогтоолд нэмэгдүүлэн тогтоохдоо - Хотын захиргааг ҮЭ гишүүн, 4 орлогч гишүүнээр байгуулжээ. - Хотын их хурлыг 1932- 11 -1-нд хийлгэх - Хотын захиргааны орлого зарлагын төсвийг ялган салгаж 1933 оны 1-р сараас эхлэн явуулах хүртэл хот ба Төв аймаг хоёрын зардлыг нэгтгэсэн төсвөөс гүйцэтгэж байхаар заажээ.

1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.

1933 оны СнЗ дахин шинэ дүрэм баталж УБХ-ын захиргааг СнЗ-д шууд харьяалуулан захирагдах засаг захиргааны нэгж болгосон. тэр жилдээ хотыг 6 хороо болгож хороодын дарга нарт сумын даргын эрх үүргийг гүйцэтгүүлэв..

1933 оны 12 дугаар сарын 29-энд Сайд нарын Зөвлөлийн 42 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл ээр 1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан бөгөөд бүтцийг нь:

- Аж ахуйн хэлтэс
- Санхүүгийн хэлтэс
- Паспорт, бичиг эрхлэх хэлтэс
- Ардын гэгээрэл боловсролын тасаг
- Хотын ариун цэврийн хянан харгалзах газар
- Бичиг хэргийн анги
- Барьцаалан зээлдүүлэх Ломбардын газар
- Галын аюулаас хамгаалах газар
- Цагдан сэргийлэх газар
- Шүүх
- Прокурор зэрэг байна.

1936 онд Аж Үйлдвэрийн комбинатын дэргэд 7 хороог 21 хорин тойгоор байгуулсан.

1936 онд СнЗ-өөс хотыг газар нутгийг шинэчлэн олгожээ. /Өмнө тал нь Туулын хөвөө, Зайсан толгойн ам бүхлээр нь баруун тал нь Яармагийн амнаас Толгойтын Баян хошуу, Зүүн талыг Улиастайн бургаснаас Хөлийн модчины ногоон мод хүртэлх газрыг олгосон.

1937 оны 2 дугаар сарын 13-анд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн “Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам” болгохоор тогтоосон байна.

1937 оны 2 сарын 5-анд СнЗ-ийн тогтоолоор Улаанбаатар хотын Захиргааны эрхийг өргөтгөн яамны эрх хэмжээнд хүргэж, хотыг захирах яам хэмээн нэрлэж яамны даргыг СнЗ-ийн жинхэнэ гишүүн болгожээ.

1937 оны 05 дугаар сарын 4-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталсан ба үндсэн хуулийн дагуу нийслэл хотын яам нь хотын ба хороодын хурлаар батлагдахаар заажээ.

СнЗ, Улсын бага хуралд захирагдах ба сайд нь СнЗ-ийн гишүүн байхаас гадна хотыг захирах яам нь 9 тэргүүлэгч, 3-н орлогчтойгоо хотын хурлаас сонгогддог байсан.

1937 оны 02 дугаар сарын 13- анд Сайд нарын Зөвлөлийн 2 дугаар хурал, Улаанбаатар хотын Тэргүүлэгчдийн 4 дүгээр тогтоолоор 02 зүйлээр Улаанбаатар хотын захиргааг өөрчлөн "Улаанбаатар хотыг захирах яам" болгосон.

1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

Мөн яам нь Сайд нарын /Зөвлөлийн гишүүн байна гээд дотоод байгуулалтыг / - Хотын байдлыг сайжруулах хэлтэс, энэ хэлтэст харьяалагдах

- Орон сууцны тасаг
- Түлээ модны бэлтгэлийн газар
- Захирах тушаах хэлтэс
- Санхүүгийн хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Ардын соёл боловсруулах хэлтэстэй байна гэжээ.

Мөн яамны шууд захиргааны газрууд:

- Амгалан баатар хотын захиргаа
- Хороо, хориодын захиргаанд
- Хотын өнчин ядуусыг тэтгэх газар
- Хүн эмнэлгийн салбар газрууд
- Тусгай дүрмээр хотын хэмжээнд дээр ажиллах газрууд
- Хотын прокурорууд - Хотын шүүх таслах газар
- Хотын хоршооны байгууллагууд
- Барьцаалан зээлдүүлэх ламфортын газар
- Хотын доторх артель, нэгдэл, үйлдвэр, мал эмнэлгийн ажил явуулах удирдлага

нөлөөг үзүүлнэ гэжээ.

1937-5-4-нд УБХ-ын тэргүүлэгчдийн хурлаар нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

Мөн дүрмийн 4-р бүлэгт Хот захирах яамны дотоод зохион байгуулалт нь

- Хот сайжруулах хэлтэс /орон сууцны тасаг, түлээ мод бэлтгэх газартай/
- Захирах тушаах хэлтэс
- Санхүүгийн хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Ардын боловсролын хэлтэс
- Пи оны /паспортын/ хэлтсүүдтэй байх.

Мөн шууд захирагдах орон нутгийн чанартай газрууд нь

- Амгалан баатар хотын захиргаа,
- хороо хорьдыг захиргаа
- хотын өнчин ядуусын тэтгэх газар,
- хүн эмнэлгийн салбарууд гэж заажээ.

1932 оны 8 дугаар сарын 22-онд Сайд нарын Зөвлөлийн 9 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгаж байгуулахаар шийдвэрлэсэн юм.

1938 оны 04 дүгээр сарын 1- энд СнЗ-ийн хурлаар хот сайжруулах комиссын төслийг хэлэлцээд баталсан.

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор “хотыг захирах яам” хэмээн нэрлэхийг “Улаанбаатар хотын захиргаа” хэмээн нэрлэх болсон. 1940 онд

батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулиар “Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид” хэмээн тогтоосон.

1940-10-3-анд Сайд нарын Зөвлөлийн 50-р хурлын 8-р зүйлээр Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын хурал ба хотын захиргааны дүрмийг баталжээ.

Мөн дүр мэнд хотын захиргааны дотоод зохион байгуулалтыг :

- Санхүүгийн хэлтэс
- Ардын гэгээрлийн хэлтэс
- Эрүүлийг хамгаалах хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Хот сайжруулах хэлтэс
- Аж ахуйн хэлтэс гэж тус тус байхаар тогтоожээ.

1953 онд Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалт, орон тоо нь: - Ерөнхий хэлтэс 1- 42

- Санхүүгийн хэлтэс 1- 26
- Гэгээрлийн хэлтэс 1- 9
- Төлөвлөгөөний комисс 1-19
- Эрүүлийг хамгаалах хэлтэс 1-8
- Цэргийн хэлтэс 1- 2 - Хот сайжруулах 1- 23

Бүгд 7-123 тус тус байсан байна.

1952 оны 11 сарын 01-ээс Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа - хэмээх болсон. Бөгөөд дотоод бүтцийг нь : Бүгд 7-123 тус тус байсан байна.

1957-7-6-анд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 104-р зарлигаар үндсэн хуулийн зарим зүйлд өөрчлөлт оруулж аймгийн ба Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд дор дурдсан хэлтсүүд байхаар тогтоожээ.

Үүнд: - Төлөвлөгөөний хэлтэс

- Хөдөө аж ахуйн хэлтэс
- Зохион зааварлах хэлтэс
- Санхүүгийн хэлтэс
- Эрүүлийг хамгаалах хэлтэс
- Соёлын хэлтэс
- Гэгээрлийн хэлтэс
- Ерөнхий хэлтэс

1961-11-24-өнд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны

соёлын хэлтэс,

хөдөлмөрийн товчоо,

тээврийн хэлтсийг татан буулгаж мөн захиргааны зохион байгуулалтыг:

- Хотын төлөвлөгөөний комисс
- Эрүүлийг хамгаалах газар
- Санхүүгийн хэлтэс
- Гэгээрлийн хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Зохион зааварлах хэлтэс

Ерөнхий хэлтэс гэж баталсан.

1962 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хэмээх болсон.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс 1965 оны 04 сарын 14-ний өдөр гаргасан 79 дүгээр зарлигаар хороодыг татан буулгаж, Улаанбаатар хотод Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, гэсэн 4 районыг байгуулсан.

1965 оны 06 дугаар сарын 01-энд Сайд нарын Зөвлөлийн 601 дугаар тогтоолоор Улаанбаатар Хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг

- Зохион зааварлах хэлтэс
- Санхүүгийн хэлтэс
- Гэгээрлийн хэлтэс
- Соёлын хэлтэс
- Ерөнхий хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Статистикийн товчоо
- Хөдөлмөр цалин хөлсний товчоо
- Төлөвлөгөөний комисс
- Иргэний хамгаалалтын штаб гэж батлаад орон тоог 60 нэгжээр баталжээ.

1965-7- 21-энд Сайд нарын Зөвлөлийн 269-р тогтоолоор аймгууд болон хотын аюулаас хамгаалах хэлтэс, цагдан сэргийлэх хэлтсийг нэгтгэж, нийгмийг аюулаас хамгаалах хэлтэс болгон байгуулжээ.

1965-6-11-энд Сайд нарын Зөвлөлийн 190-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг

- Зохион зааварлах хэлтэс
- Санхүүгийн хэлтэс
- Гэгээрлийн хэлтэс
- Соёлын хэлтэс
- Ерөнхий хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Статистикийн товчоо
- Хөдөлмөр цалин хөлсний товчоо
- Төлөвлөгөөний комисс
- Иргэний хамгаалалтын штаб гэж батлаад орон тоог 60 нэгжээр баталжээ.

1968-6-7-онд Сайд нарын Зөвлөлийн 185 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг

- Зохион зааварлах хэлтэс
- Төлөвлөгөөний комисс
- Санхүүгийн хэлтэс
- Ардын боловсролын хэлтэс
- Соёлын хэлтэс
- Их барилгын хэлтэс
- Аж ахуйн хэлтэс
- Хөдөлмөр цалин хөлсний товчоо
- Иргэний хамгаалалтын штаб

Эрүүлийг хамгаалах газар гэж батлаад орон тоог 88 нэгжээр тогтоожээ

1975-2-27-онд Сайд нарын Зөвлөлийн 104-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг дор дурдсанаар баталжээ.

- а/ Зохион зааварлах хэлтэс
- б/ Санхүүгийн хэлтэс
- в/ Төлөвлөгөөний комисс
- г/ Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс
- д/ Статистикийн товчоо
- е/ Хөдөө аж ахуйн хэлтэс
- ж/ Эрүүлийг хамгаалах газар
- з/ Ардын боловсролын хэлтэс

и/ Соёлын хэлтэс

к/ Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс

л/ Аж ахуйн хэлтэс орон тоог 89 нэгжээр тогтоожээ.

1978-9-11-энд Сайд нарын зөвлөлийн 294-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орон тоог 102 нэгжээр, зохион байгуулалтыг

а/ Зохион зааварлах хэлтэс

б/ Санхүүгийн хэлтэс

в/ Төлөвлөгөөний комисс

г/ Статистикийн товчоо

д/ Ардын боловсролын хэлтэс

е/ Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс /гадаадын харьяат иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцах тасагтай/

ж/ Орон сууц, нийтийн үйлчилгээний хэлтэс

з/ Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс

и/ Их барилгын хэлтэс

к/ Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс

л/ Соёлын хэлтэс

м/ Эрүүлийг хамгаалах газар

н/ Хөдөө аж ахуйг удирдах газар

о/ Аж ахуйн хэлтэстэйгээр баталжээ.

1978 оны Сайд нарын Зөвлөлийн тогтоол 1989 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн Сайд нарын Зөвлөлийн 152 дугаар тогтоолоор Улаанбаатар Хотын Ардын депутатуудын хурлын Гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг дарга 1, нэгдүгээр орлогч 1, Орлогч дарга 1, /Нийгэм соёл эрхэлсэн, барилгын асуудал эрхэлсэн, орон сууц, нийтийн аж ахуй, хот тохижуулах эрхэлсэн/ хариуцлагатай нарийн бичиг 1 тус тус батлаад аппаратын бүтцийг нь

Зохион зааварлах хэлтэс

Төлөвлөгөө, Эдийн засгийн хэлтэс

Санхүүгийн хэлтэс/ хянан байцаах тасагтай/

Хөрөнгө оруулалтын хэлтэс

Хөдөлмөр зохицуулах товчоо

Цэргийн хэлтэс

Аж ахуйн хэлтэс

Хууль зүй арбитрын хэлтэс

Соёлын хэлтэс

Орон сууц хуваарилалтын тасагтай байхаар тогтсон

Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд

Ардын боловсролын хэлтэс

Ахуйн үйлчилгээний Удирдах газар

Байгаль Орчныг хамгаалах газар

Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар

Тээврийг удирдах газар

Хот тохижуулах газар

Ус сувгийн ашиглалтыг Удирдах газар

Хөдөө аж ахуйг удирдах газар

Телефон радио, ашиглалтын хороо

Эрүүлийг хамгаалах газар

Нийтийн хоолны удирдах газар

Биеийн тамир спортын газар

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл зэргийг ажиглуулахаар тогтоосон